



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/385

Номгон

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд  
санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай

Аймгийн бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэх иргэдийн бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажлын байр бий болгох зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “д”, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3.2, 30.3.3, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоол, аймгийг хөгжүүлэх 2021-2025 оны үндсэн чиглэлийн 3 дугаар зүйлийн 3.1.1, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.5.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах 130.000.000 (Нэг зуун гучин сая) төгрөгийг орон нутгийн төсвөөс гэрээнд заагдсан хуваарийн дагуу аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

2. Санхүүгийн дэмжлэг арга хэмжээний 130.0 (Нэг зуун гучин сая) төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажлын байр бий болгоход зарцуулахыг аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар (Д. Амарсанаа)-т, аймгийн орон нутгийн төсвөөс 3 жилд багтаан санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөх, батлан даах гэрээ болон ажлын байр бий болгох иргэдийн бүлэгтэй гэрээ байгуулж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус тус үүрэг болгосугай.

3. Аймгийн бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэх, иргэдийн бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байр бий болгох ажлыг хэрэгжүүлэхэд хяналт тавьж, үр дүнг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн хуралдаанд 2021 оны 11 дүгээр сард багтаан хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Г.Энхбаяр)-д үүрэг болгосугай.

621010971

2.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Хөдөө аж ахуй, дэд бүтэц хариуцсан орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

